

АНУ, БНХАУ-ЫН ХООРОНД БНСУ-ЫН ТЭНЦВЭР АЛДАГДСААР БАЙНА

3.Болор

Стратегийн судалгааны хүрээлэнгийн ЗХА-ийн багийн ЭША

Оршил

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Пак Гын Хэг албан ёсоор огцруулах шийдвэр гаргаснаас хойш 60 хоногийн дотор буюу 05 дугаар сарын 09-ний өдөр ерөнхийлөгчийн сонгууль болж өнгөрлөө. Өмнөх хоёр ерөнхийлөгч консерватив намаас гарсан бол энэ удаад Ардчилсан намын нэр дэвшигч Мүн Жае Ин тус улсын ерөнхийлөгч боллоо. БНАСАУ-ын талаар баримтлах шинэ ерөнхийлөгчийн бодлого АНУ, БНХАУ-ын хооронд барих БНСУ-ын тэнцвэрт нөлөөлөх нь дамжиггүй. Үүний зэрэгцээ АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп Өмнөд Солонгост байрлах Америкийн цэргийн зардлыг нэмэгдүүлэхийг сонгуулийн компани ажлын үеэр зарлаж, ТНААД системийн зардлыг БНСУ төлөх хэрэгтэй хэмээх мэдэгдсэн явдал Сөүлд холбоотны харилцаагаа эргэн харахад хүргэж байна. Уг системийг байршуулах асуудлыг БНХАУ эрс эсэргүүцэж, БНСУ-д эдийн засгийн шахалт үзүүлж эхэллээ. БНАСАУ-ын удаа дараагийн өдөөн хатгалга Сөүл Вашингтоны батлан хамгаалах харилцааг улам бүр ойртуулж, улмаар БНХАУ, БНСУ-ын харилцаа холдуулсаар байна.

Энэхүү өгүүлэлд Солонгосын хойгийн өнөөгийн болон хэтийн нөхцөл байдлын талаар хөндөхийг зорино.

Нэг. БНСУ-ын шинэ ерөнхийлөгч Мүн Жае Инд тулгарах сорилт

Пак Гын Хэ БНСУ-ын анхны эмэгтэй төдийгүй хугацаанаасаа өмнө огцорсон “Эрх чөлөөт Солонгосын нам”¹⁴⁵-аас гарсан ерөнхийлөгч болж байна. Ерөнхийдөө Умардын талаарх Өмнөд Солонгосын байр суурийг харахад 10 жилийн давтамжтайгаар “чихэр”, “ташуур”-ын аргыг ашиглаж ирсэн байдаг. Тухайлбал, 1998 онд Ким Дэ Жун ерөнхийлөгч “Нарны элч” бодлогын хүрээнд аядуу бодлого баримталсан бол Ро Му Хён үргэлжлүүлэн хэрэгжүүлжээ. 2008 оноос Ли Ён Бак ерөнхийлөгчийн үеэс хатуу бодлого баримталж, 2012 оноос Пак Гын Хэ “итгэлцэл бэхжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлсэн боловч Умард Солонгосын өдөөн хатгалга нэмэгдсэнтэй

¹⁴⁵ өмнө нь Сэнури нам байв.

холбогдуулан Умардыг цөмийн зэвсгээс татгалзуулах, тогтоон барих хүрээнд "ташуур"-ын аргыг хэрэглэхээс өөр аргагүйд хүрсэн юм. Пак Гын Хэгийн бодлого зарим талаар хэт хатуудсан явдал түүний болон намынх нь нэр хүнд унах шалтгаан болсон хэмээн үзэж болно. Тухайлбал, олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд болон дангаар хориг тавьж, пуужингаас хамгаалах системийг суурьлуулах шийдвэр гаргасан төдийгүй хоёр Солонгосын харилцааны суурь болсон Кесоны аж үйлдвэрлэлийн цогцолборыг хаахаар шийдвэрлэсэн явдал байдлыг хурцатгах үндэс болов.

2012 оны сонгуулиар Пак Гын Хэд 3 хувийн оноогоор ялагдсан хүний эрхийн хуульч Мүн Жае Ин өмнө нь Ро Му Хён ерөнхийлөгчийн сонгуулийн компанит ажлыг удирдаж байсан ба ерөнхийлөгчийн туслах, Тамгын газрын дарга зэрэг албан тушаалыг хашиж байв.¹⁴⁶ Ро Му Хён ерөнхийлөгч "Нарны элч" бодлогыг үргэлжлүүлж ирсэн бол сонгуулийн компанит ажлын үеэр Мүн Жае Ин Пёнъяныг цөмийн хөтөлбөрөөс татгалзуулах цэргийн болон эдийн засгийн хамтын ажиллагаа бүхий "иж бүрэн арга хэмжээ" авах хэрэгтэй ..." хэмээн мэдэгсэн юм. Өөрөөр хэлбэл, Умардыг яриа хэлэлцээнд татан оролцуулах, тус улстай энхийн хэлэлцээр байгуулахаар ажиллахаа тэрээр зарласан болно.¹⁴⁷

БНСУ-ын ерөнхийлөгчид уламжлалт ёсоор хамгийн түрүүнд АНУ руу айлчилж, үүний дараагаар Япон руу айлчилдаг боловч Пак Гын Хэ хоёр дахь гадаад айлчлалаа БНХАУ-д хийн уламжлалаа эвдэж байсан удаатай.¹⁴⁸ Мүн Жае Ин ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын үеэрээ аюулгүй байдлын хямралыг шуурхай шийдвэрлэхээ амласан¹⁴⁹ тул мөн адил эхлээд АНУ дараа нь БНХАУ руу айлчилж болзошгүй юм. Тэрээр мөн Умард Солонгост айлчлах сонирхолтой байгаагаа ч мэдэгдээд байна. Мүн Жае Ин ТНААД системийг суурьлуулахыг шүүмжилж ирсэн бол сүүлийн үед тус систем болон зардлын асуудлыг АНУ-д төлөх эсэхийг парламентаар хэлэлцүүлэн зөвшилцлөөр шийдвэрлэх хэрэгтэй¹⁵⁰ хэмээн ярих болсон юм. Түүний "хоёрдмол" байр суурь удахгүй тодорхой болно гэж судлаачийн зүгээс харж байна.

¹⁴⁶ Yonhap news, Election special coverage, Moon Jae-in

¹⁴⁷ The Hankyoreh, "If elected , Moon Jae-in envision S.Korea playing leading role in the Northeast Asian order", April 24, 2017

¹⁴⁸ Victor Cha, Ellen Kim, "Between a Rock and a Hard Place: South Korea's strategic dilemmas with China and the United States", Asia Policy, #21, Jan 2016, P101-121

¹⁴⁹ Pamela Boykoff , James Griffiths "South Korea's new president wants to reverse its North Korea policy", CNN, May 10, 2017

¹⁵⁰ Yonhap news, "Presidential candidates wrangle over Trump's remarks on missile defense cost", Apr 28, 2017

Солонгосын хойгийн асуудлаар баримтлах Сөүлийн бодлогын давтамж болон шинэ ерөнхийлөгчийн бодлого зөөлрөх хандлага илэрч байна. Гэвч Солонгосын хойгийн цагийн байдал хурцадмал хэвээр тул Мүн Жае Инд аядуу бодлого баримтлахад хүндрэл учирч болзошгүй юм. Энэ бүхэн БНСУ-ын шинэ ерөнхийлөгчид БНАСАУ-ын талаар баримтлах бодлого, АНУ, БНХАУ-ын хооронд тэнцвэрийг хадгалах¹⁵¹ зэрэг сорилтыг даван туулах шаардлагыг үүсгэж байна.

Хоёр. БНСУ, АНУ-ын холбоотны харилцаа цаашид улам нягтарна

АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп сонгуулийн компанит ажлын үеэрээ Өмнөд Солонгост байрлах Америкийн цэргийн зардлыг нэмэгдүүлэхийг шаардаж, эс бөгөөс цэргээ татна хэмээн мэдэгдэж байв. Харин 2017 он гарсаар АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жеймс Маттис болон Төрийн нарийн бичгийн дарга /цаашид ТНБД гэх/ Рекс Тиллерсон нар анхны гадаад айлчлалаа холбоотнуудаасаа эхэлсэн явдал Вашингтон холбоотны харилцаандаа чухал ач холбогдол өгөхийг илтгэж байна. Гэвч БНСУ-ын ерөнхийлөгчийн сонгууль болохоос арваад хоногийн өмнө ТНААД системийг суурьлуулахад зарцуулсан нэг тэрбум ам.долларыг Өмнөд Солонгосоор төлүүлэх хүсэлтэйгээ Д.Трамп мэдэгдэж шуугиан дэгдээж амжсан юм.¹⁵² Ийнхүү Д.Трамп үе үе зардлын асуудлыг хөндөж буй явдал нэг талаас холбоотны харилцаанд сөргөөр нөлөөлж¹⁵³ болзошгүйгээс гадна нөгөөтэйгүүр, хоёр улсын яриа хэлэлцээг хөтлөх “хөшүүрэг” болж мэдэх юм.¹⁵⁴ Өөрөөр хэлбэл, хоёр орны хооронд байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээрийг сайжруулах хийгээд батлан хамгаалах салбарын өндөр зардлыг бууруулах оролдлогын эхлэл байж болох юм.¹⁵⁵

• Америкийн цэргийн зардал

Эдүгээ Өмнөд Солонгост 28.500 америк цэрэг алба хааж буй бөгөөд Сөүлийн зүгээс 1991 оноос хойш АНУ-ын цэргийн зардалд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж иржээ.¹⁵⁶ 2014 онд АНУ, БНСУ хооронд

¹⁵¹ Ho-Ki Kim, “Out of the Shadows: The collapse of Park Geun-hye and the Future of South Korea”, Global Asia Vol.1 1, No.4, Winter 2016, P80-85

¹⁵² Yonhap news, “Trump puts alliance on edge with THAAD cost pressure”, Apr 29, 2017

¹⁵³ Хандун их сургуулийн профессор Пак Вонгон “Trump's victory heightens policy uncertainty for S.Korea: experts”, Yonhap news, Nov 09, 2016

¹⁵⁴ Солонгосын Батлан хамгаалах, аюулгүй байдлын чуулга уулзалт, ахлах судлаач Ян Вук, KBS world, “Trump issue 3: Cost sharing for US Forces Korea”, Nov 10, 2016

¹⁵⁵ Yonhap news, “S.Korean, U.S security chiefs reaffirm no THAAD payment by Seoul”, Apr 30, 2017

¹⁵⁶ BBC, US Defense chief Mattis days South Korea alliance is 'strong', Feb 02, 2017

байгуулсан Онцгой арга хэмжээний гэрээ (БМА)-нд зааснаар 2014-өөс 2018 он хүртэл Сөүл Америкийн цэргийн зардалд 2014 онд 6 хувиар нэмэгдүүлэхээр тохирч¹⁵⁷. цаашид инфляцийн түвшинг харгалзан нэмэгдүүлэхээр болсон юм.¹⁵⁸ Генерал Винсент К.Бруксын мэдүүлснээр БНСУ 2015 онд 824 сая ам.доллар, 2016 онд 821 сая ам.долларыг төлсөн явдал АНУ-ын цэргийн зардлын 50 хувьд хүрч байгаа аж.¹⁵⁹ Харин БНСУ-ын Батлан хамгаалах яамны тайланд үндэслэн Өмнөд Солонгосын судлаачийн тооцоолсноор тус улс 2014 онд 799.01 сая ам.доллар АНУ-д төлсөн явдал нийт зардлын 70 хувьд хүрсэн аж.¹⁶⁰ Өмнөд Солонгос бусад холбоотноос их буюу ДНБ-ий 3 хувийг АНУ-ын цэргийн зардалд зарцуулж байгаа юм. ¹⁶¹ Угтаа цэргийн асуудлыг зөвхөн Д.Трамп ярьсан хэрэг огт биш ерөөс холбоотон улсуудын эдийн засаг өссөөр байхад тэднийг АНУ хэдий хүртэл хамгаалах болон Солонгосын нэгдлийн дараа Вашингтон, Сөүлийн холбоотны харилцаа хэрхэн хөгжих талаарх судлаачдын үзэл бодол зөрчилдсөөр ирсэн байдаг.

- **Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудал дээр улам нягт хамтарч ажиллана**

Умард Солонгосын цөмийн хөтөлбөр АНУ, БНСУ холбоотны харилцааны суурь асуудал байсаар ирсэн юм. 2009 оноос холбоотнууд Умард Солонгосын асуудлаар хамтарсан арга хэмжээ хэрэгжүүлэх болсон бол 2016 оноос улс тус бүр дангаар хориг тавихаас гадна нэгэн зэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хатуу хориг тавихыг дэмжиж, пуужингаас хамгаалах ТНААД системийг байршуулахаар хэлэлцсэн зэргээс харахад тэд үйл ажиллагаагаа уялдуулж, бүх талаар хамтарч ажиллаж байна. Үүнд:

- **АНУ, БНСУ-ын цэргийн хамтарсан сургуулилт эхэлснээс таван өдрийн дараа Умард Солонгос баллистик пуужин хөөргөлөө**

АНУ, БНСУ-ын “Бүргэд” (Foal Eagle) агаар, тэнгис, хуурай замын хамтарсан сургуулилт 2017 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарыг дуустал үргэлжилж, нийт 300.000 Өмнөд Солонгосын цэрэг, 17.000 Америкийн цэрэг оролцсон түүхэндээ хамгийн том сургуулилт болсон юм.

¹⁵⁷ 867 сая ам.доллар

¹⁵⁸ Asia Pacific Regional security Assessment 2015 key developments and trends, “Chapter 8: South Korea's regional relations”, P119-130

¹⁵⁹ Congressional Research Service report, “U.S-South Korea relations”, Oct 2016

¹⁶⁰ Park Byong-su, “Sorry, Trump: South Korea actually covers more like 70% of US troops stationing costs”, The Hankyoreh Media, May 09, 2016

¹⁶¹ Robert Manning, Senior analyst at the Atlantic Council think tank, “Amid Trump’s call for NA TO burden sharing, experts say S. Korea different from NA TO”, Feb 9, 2017

Харин Үндсэн шийдэл (Key Resolve) компьютер суурьтай сургуулилт 2017 оны 03 дугаар сарын 13-наас 10 өдөр үргэлжилсэн бөгөөд энэ удаагийн сургуулилтыг БНСУ-ын хамтарсан штабын ахлагч удирдсан юм. 2013 онд Key Resolve сургуулилтыг БНСУ мөн удирдаж, 2015 онд АНУ-аас үйл ажиллагааны удирдлагыг (OPCON) авах байсан боловч Умардын өдөөн хатгалга, “цагийн байдлаас шалтгаалан” удирдлагаа шийдвэрлэхээр тохиролцсон юм. Энэхүү сургуулилтыг Умардын өдөөн хатгасан үйлдэлд бэлтгэлтэй байх үүднээс хийхийн зэрэгцээ түүгээр дамжуулан АНУ, БНСУ холбоотны харилцаагаа улам бэхжүүлж, Өмнөд Солонгосыг хамгаалахад бэлэн гэдгээ Пёнъянд харуулахад оршдог болно.¹⁶² Гэвч энэ нь эсрэгээр Умард дахин пуужингийн туршилт хийх шалтаг, Солонгосын хойгийн байдлыг хурцатгадаг талтай.¹⁶³ ¹⁶⁴ Тухайлбал, 2016 оны 09 дүгээр сарын 06-нд АНУ, БНСУ-ын “Ulchi” сургуулилт эхэлснээс нэг өдрийн дараа, 2017 онд 03 дугаар сарын 06-нд “Foal Eagle” сургуулилт эхэлснээс таван хоногийн дараа Умардын тал тус тус баллистик пуужин хөөргөж, эсэргүүцлээ илэрхийлжээ.

- Пуужингаас хамгаалах ТНААД систем ашиглалтанд орлоо

2016 оны 7 сард Өмнөд Солонгосын Сёнгжу хотноо ТНААД системийг 2017 оны сүүлээр байршуулахаар шийдвэрлэсэн бол 2017 оны 02 дугаар сарын 28-ны өдөр БНСУ-ын Батлан Хамгаалах Яам, Лотте групптэй Сёнгжу хотын Гольфын талбайг ашиглах гэрээ хийсэн бөгөөд 03 дугаар сарын 02-ны өдөр АНУ, БНСУ-ын хооронд албан ёсоор хэлэлцээ эхэлсэн юм.¹⁶⁴ Мөн 03 дугаар сарын 06-ны өдөр ТНААД системийг байршуулах эхний хэсэг Пёньтак дахь Осан агаарын баазад хүрч¹⁶⁵ Умардын баллистик пуужингаас хамгаалахад бэлэн болсон хэмээн Ёнхап мэдээллэсэн¹⁶⁶ бол гадны эх сурвалжийн харж байгаагаар уг систем үйл ажиллагааны эхний үе шатанд хүрсэн гэх аж. Ийнхүү Умардын пуужингийн туршилт, БНХАУ-ын эсэргүүцлээс үл шалтгаалан АНУ, БНСУ пуужингаас хамгаалах системийг байрлуулах үйл ажиллагаагаа эхлээд байна.

Гурав. БНХАУ БНСУ-ыг хатуу шийтгэж байна

¹⁶² Robert Collins, “A Brief history of the US-ROK combined military exercises”, 38 North, Feb 24, 2014

¹⁶³ The Japan Times, “South Korea, U.S. begin annual military drills amid North Korean threat”. Mar 01, 2017

¹⁶⁴ Yonhap news, “Negotiations launched officially to provide S.Korean land for THAAD deployment”, Mar 02, 2017

¹⁶⁵ Yonhap news, “S.Korea begins process to deploy THAAD: military”, March 07, 2017

¹⁶⁶ Yonhap news, “USFK: THAAD in operation against N. Korean missiles”, May 02, 2017

2016 оны 7 сард Өмнөд Солонгосын Сёнгжу хотноо ТНААД системийг байршуулахаар шийдвэрлэсэн цагаас уг системийн радарын хамрах хүрээ Солонгосын хойгоор хязгаарлагдахгүй, БНХАУ-ын пуужингийн байршлыг хянана хэмээн Бээжин албан ёсоор эсэргүүцлээ илэрхийлсэн юм. Үүнээс гадна Лотте группын эзэмшил Гольфын талбайд байршуулахаар ярилцах үеэс Лотте группт шууд бусаар БНХАУ шахалт үзүүлж байна. Энэ үйл явц дараах байдлаар илэрнэ.

- **БНХАУ-ын байр суурь**

ТНААД системийг байршуулах асуудалд БНХАУ-ын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч¹⁶⁷ болон БХЯ-ны төлөөлөгч дараах байр суурьтай байна. Нэгд, "... БНХАУ, ОХУ зэрэг хөрш зэргэлдээ орнуудын ашиг сонирхол, стратегийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулна ... ", хоёрт, "... бүс нутаг дахь стратегийн тэнцвэртэй байдлыг алдагдуулна ... ", гуравт, "... шаардлагатай тохиолдолд Хятадын зэвсэгт хүчин аюулгүй байдлаа хамгаалахын тулд зайлшгүй арга хэмжээ авах болно ..." гэжээ. Мөн ХАЧА-ийн бэлтгэл офицер, батлан хамгаалахын мэргэжилтэн Сун Жунпин "... ТНААД-ыг байршуулвал ХАЧА-ийн пуужингийн систем Сёнгжу хотыг онилох болно ... " гэв.¹⁶⁸ Харин Хятадын ард иргэд Лотте группыг боймлож буй эсэх талаар асуухад "... Хятадад бизнес эрхэлж буй бүх гадны компани БНХА У-ын хууль дүрмийг чандлан сахих ёстой бөгөөд хэрэглэгчээ алдах явдал тухайн компанийн амжилтын асуудал ..." хэмээн хариулжээ.

- **Хятад дахь Лотте группын бизнесийн алдагдал бол зөвхөн эхлэл**

Өмнөд Солонгосын гэр бүлийн эзэмшлийн тав дахь том корпорац болох Лотте групп Хятадад 22 салбар компанитай, 20.000 хүнийг ажлын байраар хангаж, үйл ажиллагаагаа явуулж иржээ. Түүнчлэн Лотте группын 5 их дэлгүүр, 99 худалдааны төв, 16 супермаркетын сүлжээ дэлгүүр, 12 кино театр Бээжин, Шанхай, Шэньянд бий.¹⁶⁹ Эдгээр аж ахуйн нэгжийн ихэнхийг галын шалгалтаар шаардлага хангаагүй хэмээн хааснаар одоогийн байдлаар 5 их дэргүүр, 44 худалдааны төв, 13 супермаркет үлдсэн байна. Мөн Лотте группын татваргүй барааны дэлгүүр нийт борлуулалтын 80 хувь буюу 2.6 тэрбум ам.долларын ашгийг Хятадын жуулчдаас олдог.¹⁷⁰ Гэтэл Сёнгжу хотноо Лотте группын эзэмшил бүхий гольфын талбайд ТНААД системийг

¹⁶⁷ 2017^24278, 3月2日外交部发言人耿爽主持例行记者会 www.fmprc.gov.cn

¹⁶⁸ Korea Joongang Daily, "China threatens Korea over THAAD", March 02, 2017

¹⁶⁹ The Hankyoreh, "With consumer boycotts over THAAD, S.Korea-China relations in a tailspin", March 1, 2017

¹⁷⁰ The Hankyoreh, "Lotte keeping quiet about motion to use golf course as THAAD deployment site", Feb 28, 2017

байршуулахаар зарласны дараа 2016 оны 11 дүгээр сард Лоттегийн 150 гаруй үйлдвэр, агуулах, дэлгүүрт татварын болон хөдөлмөр хамгааллын шалгалт оржээ.¹⁷¹ 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдөр галын шалгалтын дараа тус группын Хятад дахь барилгын төслийг БНХАУ-ын засгийн газраас зогсоолоо хэмээн Лотте групп мэдэгдсэн юм.¹⁷² Харин 02 дугаар сарын 28-ны өдөр газар солилцох гэрээ хийсний дараа Лотте-гийн Хятад дахь цахим хуудас хакердуулжээ.¹⁷³ Хятадын компаниуд Лотте групптэй байгуулсан гэрээгээ цуцалж, цаашид хамтран ажиллахгүй, тус группын бараа бүтээгдэхүүнийг авахгүй байхыг уриалсан нийтлэл гарсаар байна. ¹⁷⁴ Хятадын дарамт зөвхөн Лотте группт алдагдал учруулаад зогсохгүй автомашин үйлдвэрлэгч Хьюндай, Киа-ын борлуулалтад мөн нөлөөлж өмнөх онтой харьцуулахад 52 хувиар буурчээ.¹⁷⁵

- **Аялал жуулчлалын салбар**

Хятадын төрийн аялал жуулчлалын агентлаг Өмнөд Солонгос руу аялалын хөтөлбөрийг цуцлах зааварчилгаа аялал жуулчлалын агентлагуудад өгсөн гэх мэдээлэл цацагдав.¹⁷⁶ Үүний улмаас 3.000 хятад хэлтэй Өмнөд Солонгосын хөтөч ажилгүй болжээ.¹⁷⁷ Чэжү аралд аялах Хятадын жуулчдын тоо өмнөх онтой харьцуулахад 6.7 хувиар буурсан байна.

Солонгосын Аялал жуулчлалын байгууллагаас гаргасан тооцоогоор 2016 онд нийт жуулчдын 44 хувь болох Хятадын 8 сая жуулчин БНСУ-д аялсан бөгөөд нэг хүн дунджаар 2.080 ам.доллар зарцуулсан аж.¹⁷⁸ Ийнхүү Хятадын жуулчид эрс багассан тул Korean airlines компани Хятад руу үйлддэг нийт 1200 нислэгийн 6.5 хувь болох 8 чиглэлийн 79 нислэгийг түр зогсоосон бол “Asiana Airlines” компани 8 чиглэлийн 90 нислэгээ цуцалахаас өөр аргагүйд хүрчээ.¹⁷⁹ Иймээс Хятадын жуулчдыг Япон, Зүүн Өмнөд Азийн жуулчдаар орлуулахаар БНСУ хичээн ажиллаж байна. Хятадад аялах 26 сая

¹⁷¹ Korea Joongang Daily, “Beijing encourages boycott of Lotte over THAAD”, March 02, 2017

¹⁷² The Japan Times, “China threatens boycott after South Korea missile defense decision”, Feb 28, 2017

¹⁷³ Korea Herald, “Lotte’s Chinese website hacked in protest against THAAD”, March 02, 2017

¹⁷⁴ 罗缓, “反制萨德十策”, 环球时报, 2017年03月2日, 第4232期 (Global Times)

¹⁷⁵ Celine Ge, “South Korea’s Hyundai, Kia sales halve in China amid diplomatic spat over THAAD”, South China Morning Post, Apr 05, 2017

¹⁷⁶ Yonhap news, “S.Korea –China crisis to deepen as THAAD deployment kick starts”, March 07, 2017

¹⁷⁷ The Chosunilbo, “3000 tour guides left high and dry by Chinese Boycott”, March 22, 2017

¹⁷⁸ Yonhap news, “S.Korea’s economic growth may slow on THAAD impact: analysts”, March 08, 2017

¹⁷⁹ The Chosunilbo, “Airlines cut back on flight to China”, March 15, 2017

жуулчдын 17 хувийг Өмнөд Солонгосын жуулчид эзэлж байгаа тул Хятадын хувьд ч мөн алдагдалтай юм.

- **Соёл, урлагийн салбар**

Өнгөрсөн оноос Солонгосын поп оддын Хятад дахь аялан тоглолт визний асуудлаас болж хүлээлэгт орж, хоёр орны хамтарсан кино зургийн ажлыг шалтгаангүйгээр цуцлаж, ¹⁸⁰ Хятадын видеог түгээдэг “Youku” цахим хуудас болон телевизийн агентлаг Солонгосын олон ангит киног гаргахаа зогсоов.¹⁸¹

Дүгнэлт

БНСУ-ын гадаад бодлого боловсруулагчдад БНАСАУ-аас гадна АНУ, БНХАУ-ын хооронд тэнцвэрээ хадгалах явдал маш том сорилт болдог. Өмнөд Солонгос, АНУ-тай батлан хамгаалах салбарын шинэчлэл, цэргийн хээрийн сургуулилт зэрэг нягт аюулгүй байдлын хамтын ажиллагаагаар аливаа эрсдлээс хамгаалдаг. Харин БНХАУ-аас худалдаа, эдийн засгийн хамааралтай тул АНУ-тай эдийн засгийн салбарт хамтарч ажиллах боломжийг нэмэгдүүлэхээр хичээдэг. 2016 оноос БНАСАУ хоёр удаагийн цөмийн туршилт болон баллистик пуужин хөөргөснөөр аюулгүй байдлаа хамгаалахад АНУ-тай улам нягт хамтарч, цэргийн сургуулилт, пуужингаас хамгаалах системийг суурьлуулахаар болсон юм. Гэтэл БНХАУ-ын зүгээс эдийн засгийн дарамт шахалт үзүүлсэнээр БНСУ-ын тэнцвэр алдагдсаар байна.

БНСУ-ын шинэ ерөнхийлөгч Мүн Жае Иний хувьд БНАСАУ-ын асуудлаар аядуу бодлого баримтлах хандлагатай буюу тэрээр “шинэ иж бүрэн арга хэмжээ” авна хэмээн амлаж байгаа хэдий ч 10 жилийн өмнө “Нарын элч” бодлогыг хэрэгжүүлэх тухайн үеийн нөхцөл байдал огт өөр байсан юм. Нөгөө талаар, БНАСАУ-ын зүгээс дахин цөмийн болон пуужингийн туршилт хийвэл АНУ-тай нягт хамтран ТНААД системийг ашиглахаас өөр аргагүйд хүрч, БНХАУ-аас дарамт шахалтаа үргэлжлүүлсээр байх болно.

Мүн Жае Инийг ерөнхийлөгч болсонд БНХАУ-ын дарга Си Зиньпин хамгийн түрүүнд баяр хүргэхийн ялдамд хоёр орны харилцааг чухалчилж буйгаа мэдэгдсэн явдал¹⁸² ТНААД-ыг зогсоохыг сануулж буй хэрэг юм. Харин АНУ-ын зүгээс шинэ ерөнхийлөгчийг албан ёсоор Вашингтонд

¹⁸⁰ 陈尚文, 张静, 蓝雅歌, “韩国争议中启动萨德部署”, 环球时报, 2017年03月1日, 第4231期

¹⁸¹ Youkyung Lee, Christopher Bodeen, “Candy, makeup, K-pop get doused amid China’s ire over THAAD”, March 19, 2017

¹⁸² 环球时报, “习近平与韩国总统通电话”, 2017年5月12日, 第4189期

айлчлахыг урьсан бол Мүн Жае Ин “БНСУ-ын дипломат, аюулгүй байдлын бодлогын суурь бол хоёр орны холбоотны харилцаа мөн ”¹⁸³ хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү Солонгосын хойгийн тодорхойгүй байдал Мүн Жае Ин ерөнхийлөгчийн хоёрдмол байр суурь хэр тодорхой болох, АНУ,БНХАУ-ын хооронд хэрхэн тэнцвэржүүлэхээс шалтгаалах боллоо.

Эх сурвалжийн жагсаалт

- Asia Pacific Regional security Assessment 2015 key developments and trends, “Chapter 8: South Korea’s regional relations”, Pl 19-130
- Victor Cha, Ellen Kim, “*Between a Rock and a Hard Place: South Korea’s strategic dilemmas with China and the United States*”, Asia Policy, #21, Jan 2016, P101-121
- David Kang, “*The balance of power and state interests in international relations: South Korea between China and the US*”, EAI Working paper series V
- David F.Helvey, “*Korean Unification and the future of the US-ROK alliance* ”, Institute for National Strategic Studies, National Defense University, Feb 2016
- Laura Pascall, “*Are US allies Japan and South Korea hedging China?* ”, Massey University, 2013
- Daniel Bob, “*A US Perspective Japan and South Korea grapple with Trump’s foreign policy uncertainty*”, Global Asia, Vol. 12, No.1, Spring 2017
- T.J.Pempel “*A US Perspective America’s recalcitrant allies and obstacles to closer ties* ”, Global Asia, Vol. 12, No.1, Spring 2017
- Theodore A.Postol, George N.Lewis, “*The illusion of Missile defense: Why THAAD will not protect South Korea*”, Global Asia, vol.1 1, No.3, Fall 2016

¹⁸³ Yonhap news, “Moon, Trump agree to maintain close cooperation over N.K. nuke threats”. May 11,2017